

**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2025 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.07.29

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

“Монголын төмөр зам” /МТЗ/ ТӨХК-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

“МТЗ” ТӨХК-ийн 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 83.1%-тай байна.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. “МТЗ” ТӨХК-ийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
36	16	1	2	-	8	5	4	64.7

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
13	9	2	2	-	81.8

2.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	

16	11	4	-	1	73.3
----	----	---	---	---	------

2.4. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
2	2	-	-	-	100.0

2.5. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
төсөв, гүйцэтгэл	14	6	-	-	-	8	100.0
хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	6	4	-	-	-	2	100.0
бусад	8	5	-	-	-	3	100.0
Нийт	28	15	-	-	-	13	100.0

2.6. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Нийт заалт	Үүнээс							Биелэлтийн хувь
	100%	70%	50%	30%	0%	ХБ	Хамаа ралгүй	
46	26	2	3	6	2	1	6	78.7

Гурав. Дүгнэлт

I. Төлөвлөлтийн байдал

“МТЗ” ТӨХК нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээний зорилтот түвшнийг улирал бүрээр төлөвлөөгүй байна. /1.4, 1.7, 1.9, 1.11, 1.15, 2.1, 2.2, 2.3, 3.3, 6.1, 6.2/

II. Хэрэгжилтийн байдал:

1. “МТЗ” ТӨХК-ийн 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 83.1%-тай байна.

2. “Зүтгүүрийн урсгал засвар хийх тусгай зөвшөөрөл”-ийг шинээр авах, Замын-Үүд сум дахь “Бүс нутгийн логиستيкийн төв”-ийн ашиглалт, эзэмшилтэй холбоотой үүссэн техник, технологийн болон санхүүгийн асуудлуудыг шийдвэрлэх ажлуудын хангалтгүй хэрэгжүүлж ажиллажээ.

3. Түүнчлэн 35/10 кВ-ын Шинэ өртөө дэд станцаас 35/0.4 кВ-ын Хонгор толгой дэд станц хүртэлх цахилгаан дамжуулах агаарын шугамын эхэнд 2 иж бүрэн реклоузер суурилуулах, аюултай хог хаягдлын цэг байгуулах ажлын худалдан авалтыг зохион байгуулж, гэрээ байгуулахад шаардлагатай төсөв батлагдаагүй, санхүүжилтийн эх үүсвэр бүрдээгүй тул эдгээр арга хэмжээнүүд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй байна.

4. Шивээхүрэн-Сэхээ боомтыг төмөр замаар холбох хэлэлцээр хийх асуудал Хятадын талын шийдвэр гараагүй байгаагаас үүдэн хэрэгжээгүй байна.

5. Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвд нүүрс ачилтыг тогтмол гүйцэтгэхэд шаардлагатай техник, автомат удирдлагын системийн эвдрэл, нүүрсний овоолго, бункерийн нөөц, тэжээл зэрэг хүчин зүйлс хангалтгүй байснаас хоногт ачих ачилтын зорилт биелээгүй байна.

6. Тус компанийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 36 арга хэмжээний хэрэгжилт 64.7% байна. Үүнээс 59.4% нь хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн болон хүрэх шатандаа, 40.6% нь төлөвлөсөн үр дүндээ бүрэн хүрээгүй байна

7. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
Зорилт 1. Төмөр замын тээврийн хэмжээг нэмэгдүүлнэ.	15	52.3
Зорилт 2. Төмөр замын төслийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.	6	32.0
Зорилт 3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллана.	6	71.7
Зорилт 4. Ажилтнуудын нийгмийн баталгааг хангана.	3	100.0
Зорилт 5. Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлж, компанийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулж гадаад хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	6	100.0

8. Төмөр замаар тээвэрлэх ачааны хэмжээг нэмэгдүүлэх ажлын хэрэгжилт хангалтгүй байгаа нь хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалсан. Үүнд: дэлхийн зах зээл дээр нүүрсний үнэ буурсны улмаас биржээр нүүрс арилжаалагдаагүй, хүлээн авагч тал нүүрс худалдан авахаас түр хугацаанд татгалзсан, мөн Монгол Улсын Засгийн газар болон Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооноос мидлинг (баяжуулалтын завсрын бүтээгдэхүүн)-ийн тээврийг зогсоох шийдвэр гаргасан зэрэг нь нөлөөлсөн.

9. Тус байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж өгсөн зөвлөмжүүдээс дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй, удаашралтай байна. Үүнд:

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тайлагнахдаа хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд, ажлын явц тоочилгүй, бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, тодорхой ахиц гаргах;
2. Хариуцан хэрэгжүүлж байгаа арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа дэвшүүлсэн зорилтын хүрээнд зохион байгуулсан гол ажлаа, хүрсэн үр дүн,

зорилтот түвшинтэй нь уялдуулж, зөв бичгийн алдаагүй, үр дүнг тайлагнаж хэвших;

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Сайншанд-Баруун-Урт-Хөөт төмөр зам” ХХК-д хөрөнгө оруулж, хамтран ажиллах сонирхол бүхий гадаад, дотоодын хуулийн этгээдийг сонгох ажлыг яаралтай зохион байгуулах;

2. Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвд нүүрс ачилтыг тогтмол гүйцэтгэхэд шаардлагатай техник, автомат удирдлагын системийн эвдрэл, нүүрсний овоолго, бункерийн нөөц, тэжээл зэрэг хүчин зүйлсийн хангалтгүй байдлыг яаралтай шийдвэрлэх асуудлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д уламжлан, ачилтын үйл ажиллагааг хэвийн жигдрүүлэх арга хэмжээ авах;

3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан Зүтгүүрийн урсгал засвар хийх тусгай зөвшөөрөл”-ийг шинээр авах, Замын-Үүд сум дахь “Бүс нутгийн логиستيкийн төв”-ийн ашиглалт, эзэмшилтэй холбоотой үүссэн техник, технологийн болон санхүүгийн асуудлуудыг шийдвэрлэх санал, мэдээлэл, тооцооллыг дахин боловсруулж холбогдох газарт хүргүүлэх;

4. 35/10 кВ-ын Шинэ өртөө дэд станцаас 35/0.4 кВ-ын Хонгор толгой дэд станц хүртэлх цахилгаан дамжуулах агаарын шугамын эхэнд 2 иж бүрэн реклоузер суурилуулахад шаардлагатай төсвийг тодотголд оруулж батлуулахыг түргэвчлэх;

5. Шивээхүрэн–Сэхээ боомтыг төмөр замаар холбох асуудлаар БНХАУ-ын талын шийдвэр гаргахад шаардлагатай хэлэлцээ, уулзалт, албан бичгийг дахин хүргүүлж үйл явцыг түргэтгэх арга хэмжээ авах;

6. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ыг тогтмол хэрэгжүүлж, компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг шинэчлэн холбогдох линкийг хугацаанд нь байршуулж хэвших;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР